

**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, ЭРҮҮЛ  
МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН  
ТУШААЛ**

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 7.3.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын газар (Д.Ренчиндорж), Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн бодлогын газар (Р.Гантуяа)-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Мөнхзул), Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)- т тус тус даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

САЙД

Т.МӨНХСАЙХАН

## ТАНИЛЦУУЛГА

“Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг боловсруулсан тухай

Энэхүү журмаар үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулахдаа Ахмад настны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэхүү журам болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15, 17 дугаар зүйлд заасан чадавхын болон туршлагын шаардлага, техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нэг бүрчлэн тусган боловсруулав.

---oOo---

Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын  
сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны ..  
дугаар сарын ...-ны өдрийн хамтарсан  
тушаалын хавсралт

## **АХМАД НАСТАНД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмаар Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.8, 7.1.12-д зааснаас бусад үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулахдаа Ахмад настны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, энэхүү журам болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3. Үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай, шударга өрсөлдөөнтэй байх зарчмыг баримтална.

### **Хоёр. Худалдан авах үйлчилгээ**

2.1. Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3-т заасны дагуу аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь дараах үйлчилгээг багцаар эсхүл үйлчилгээ тус бүрээр иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж гэрээлэн гүйцэтгэнэ:

- 2.1.1. идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ;
- 2.1.2. гэрээр асрах үйлчилгээ;
- 2.1.3. өдрөөр асрах үйлчилгээ;
- 2.1.4. түр болон урт хугацаагаар асрах үйлчилгээ;
- 2.1.5. байнга асрах үйлчилгээ;
- 2.1.6. төрөлжсөн асрамжийн үйлчилгээ;

2.2. Сонгон шалгаруулалтад оролцох иргэн, байгууллага нь тавигдах шаардлагыг хангасан тохиолдолд энэ журмын 2.1-т заасан үйлчилгээнээс 2 ба түүнээс дээш багц үйлчилгээг үзүүлэхээр сонгон шалгаруулалтад оролцож болно.

### **Гурав. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт**

3.1. Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3-т заасны дагуу аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулахдаа тухайн жилийн үйлчилгээний батлагдсан төсөвт өртөгт багтаан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, түүнд нийцүүлэн гарсан холбогдох журмын дагуу зохион байгуулна.

3.2. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.” гэснийг баримтлана.

3.3. Энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан үйлчилгээний нийт батлагдсан төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.

3.4. Энэ журмын 2.1-д заасан иргэн, байгууллага нь Ахмад настны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д заасны дагуу нийгмийн хамгааллын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан үйлчилгээний жишиг үнэ болон иргэний хариуцах төлбөрийн хэмжээг баримтлан үйлчилгээг үзүүлнэ.

3.5. Үйлчилгээний гэрээлэх санхүүжилтийн хэмжээ нь үйлчилгээнд хамрагдах ахмад настны тоо, түүнтэй уялдсан иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын ажилтны тооноос хамаарна.

### **Дөрөв. Үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад тавигдах шаардлага**

4.1. Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан үйлчилгээний багцыг тухайн орон нутагт ахмадын ордон, өргөө, асрамжийн газар, идэвхтэй насжилтыг дэмжих төвтэй эсэх, газар нутгийн байршил, үйлчлүүлэгчдийн тоо, зэргээс хамааран аймагт сумаар, дүүрэгт хороогоор багцлан тусгана.

4.2. Энэ журмын 2.1.1-д заасан идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулахдаа дараах шаардлагыг тусгана:

4.2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан талаарх нотлосон байх;

4.2.2. чадавхын болон туршлагын шаардлага: аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага бол хуулийн этгээдийн гэрчилгээтэй байх, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн нийгмийн ажилтан, үйл ажиллагааны менежерийг орон тоогоор, багш, сэтгэл зүйч, эмч, хуульч, сувилагч, үйлчилгээний ажилтанг гэрээгээр, боловсон хүчин мэргэжлийн дипломтой байх, ажилтны ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолттой байх, идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээний хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх, ахмад настны тоо, хуваарь, өрөө тасалгаа, байршлаар 7 хоног, сар бүр зохион байгуулах сургалт, арга хэмжээний төлөвлөгөөтэй байх, үйлчилгээ үзүүлэх заавар /дотоод журам/-тай байх, архи, мансууруулах донтой, сэтгэцийн, сүрьеэ халдварт өвчтэй хүн ажиллуулахгүй байх, сүүлийн гурван жилийн үйл ажиллагааны тайлантай байх;

4.2.3. техникийн чадавх болон туршлагын шаардлага: өөрийн өмчийн эсвэл түрээсийн байртай байх, аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орчин, хүртээмжтэй дэд бүтэцтэй, интэрнет, харилцаа холбоотой байх, байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан байх, идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ үзүүлэх анги танхим, техник, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнтэй байх, хот, суурин газар байрладаг бол төвийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны хангамжинд

холбогдсон, яаралтай үед хэрэглэх эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байх.

4.3. Энэ журмын 2.1.2-д заасан гэрээр асрах үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулахдаа дараах шаардлагыг тусгана:

4.3.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан талаарх нотлосон байх;

4.3.2. чадавхын болон туршлагын шаардлага: аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага бол хуулийн этгээдийн гэрчилгээтэй байх, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн нийгмийн ажилтан, үйл ажиллагааны менежер, сувилагч, асрагч, үйлчилгээний ажилтан орон тоогоор, сэтгэл зүйч, эмч, сайн дурын ажилтан гэрээгээр, боловсон хүчин мэргэжлийн дипломтой байх, ажилтны ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолттой байх, сургалт, кейс менежементийн багаар ажиллах хөтөлбөр, төлөвлөгөөтэй байх, хамрагдах ахмад настны тоо, хуваарь, үйлчилгээ үзүүлэх заавар /дотоод журам/-тай байх, архи, мансууруулах донтой, сэтгэцийн, сүрьеэ зэрэг халдварт өвчтэй хүн ажиллуулахгүй байх, сүүлийн гурван жилийн үйл ажиллагааны тайлантай байх;

4.3.3. техникийн чадавх болон туршлагын шаардлага: өөрийн өмчийн эсвэл түрээсийн байртай байх, байгууллагын нэр, байршил, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан байх, техник, тоног төхөөрөмж, гэрээр асрах үйлчилгээ үзүүлэх машинтай байх, утас, интэрнет, харилцаа холбооны хэрэгсэл, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байх.

4.4. Энэ журмын 2.1.3-т заасан өдрөөр асрах үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулахдаа дараах шаардлагыг тусгана:

4.4.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан талаарх нотлосон байх;

4.4.2. чадавхын болон туршлагын шаардлага: аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага бол хуулийн этгээдийн гэрчилгээтэй байх, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн нийгмийн ажилтан, эмч, сувилагч, асрагч, тогооч, туслах тогооч, үйлчилгээний ажилтанг орон тоогоор, сэргээн засалтын эмч, сэтгэцийн эмч, сэтгэл зүйчийг гэрээгээр, боловсон хүчин мэргэжлийн дипломтой байх, ажилтны ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолттой байх, сургалт, кейс менежементийн үйлчилгээний хөтөлбөр, ажиллах төлөвлөгөөтэй байх, хамрагдах ахмад настны тоо, хуваарь, өрөө тасалгаа, байршлаар, үйлчилгээ үзүүлэх заавар /дотоод журам/-тай байх, шуурхай тусламж үйлчилгээ үзүүлэх зохицуулалтай байх, камертай байх, архи, мансууруулах донтой, сэтгэцийн, сүрьеэ зэрэг халдварт өвчтэй хүн ажиллуулахгүй байх, сүүлийн гурван жилийн үйл ажиллагааны тайлантай байх;

4.4.3. техникийн чадавх болон туршлагын шаардлага: өөрийн өмчийн эсвэл түрээсийн байртай байх, аюулгүй эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орчин, хүртээмжтэй дэд бүтэцтэй, хөдөлгөөн хийх, эмчилгээ зөвөлгөөний тустай өрөөтэй байх, байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан байх, техник, тоног төхөөрөмж, автобустай байх, төвийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны хангамжинд холбогдсон, интэрнет, харилцаа холбоотой байх, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байх.

4.5. Энэ журмын 2.1.4-2.1.6-т заасан асаргааны хувилбарт үйлчилгээ худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулахдаа дараах шаардлагыг тусгана:

4.5.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагыг хангасан талаарх нотлосон байх;

4.5.2.чадавхын болон туршлагын шаардлага: аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага бол хуулийн этгээдийн гэрчилгээтэй байх, үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн нийгмийн ажилтан, эмч, сэргээн засалтын эмч, сувилагч, асрагч, тогооч, туслах тогооч, үйлчилгээний ажилтанг орон тоогоор, сэтгэцийн эмч, сэтгэл зүйчийг гэрээгээр, боловсон хүчин мэргэжлийн дипломтой байх, ажилтны ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолттой байх, сургалт, кейс менежементийн үйлчилгээний хөтөлбөр, ажиллах төлөвлөгөөтэй байх, хамрагдах ахмад настны тоо, хуваарь, өрөө тасалгаа, байршлаар, үйлчилгээ үзүүлэх заавар /дотоод журам/-тай байх, шуурхай тусламж үйлчилгээ үзүүлэх зохицуулалтай байх, камертай байх, архи, мансууруулах донтой, сэтгэцийн, сүрьеэ зэрэг халдварт өвчтэй хүн ажиллуулахгүй байх, сүүлийн гурван жилийн үйл ажиллагааны тайлантай байх;

4.5.3.техникийн чадавх болон туршлагын шаардлага: өөрийн өмчийн эсвэл түрээсийн байртай байх, аюулгүй эрүүл ахуйн шаардлага хангасан тохилог орчин, хүртээмжтэй дэд бүтэцтэй, хөдөлгөөн хийх, халуун усны, ариун цэврийн өрөө, сэргээн засалт, сургалтын өрөө, хоолны танхим, гал тогоо, угаалга, эмчилгээ зөвөлгөөний тусдаа өрөөтэй байх, байгууллагын нэр, холбоо барих утас, байршил, ажиллах цагийн хуваарийг ил тод байршуулсан байх, эрүүл мэнд, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх танхим сургалтын хэрэглэглэхүүнтэй байх, сэргээн засалт, угаалга, ариутгалын техник, тоног төхөөрөмж, автобустай байх, төвийн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны хангамжинд холбогдсон, интэрнет, харилцаа холбоотой байх, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх хэрэгсэлтэй байх.

4.6.Энэ журмын 2.1.6-д төрөлжсөн асрамжийн үйлчилгээний худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулахдаа чадавхын болон туршлагын шаардлага, техникийн чадавх болон туршлагын шаардлагыг боловсруулахдаа “Ахмад настны асрамжийн үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага” Монгол Улсын стандартад нийцүүлнэ.

## **Тав. Бусад**

5.1.Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтан энэ журмын 2.1.1-2.1.6-д заасан үйлчилгээний тендер шалгаруулалтын зарлалыг tender.gov.mn цахим системээс гадна улс, орон нутгийн хэвлэл, телевиз, нийгмийн сүлжээ зэрэг мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас, байгууллагын самбар зэрэгт байрлуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад сургалт, сурталчилгаа хийж сонгон шалгаруулалтын ил тод байдлыг ханган ажиллана.

5.2.Сонгон шалгаруулалттай холбоотой гомдол, маргааныг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ авах тухай хууль болон холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэнэ.

5.3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол буруутай албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн 48.1, хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2-т заасан сахилгын шийтгэлийг зөрчлийн шинж байдалд тохируулан ногдуулна.